

## НОМЫН ШҮҮМЖ

**Монгол, Хятадын эрдэс баялгийн салбар дахь харилцаа,  
хамтын ажиллагааны асуудлыг хөндсөн нэгэн сонирхолтой  
бүтээлийн тухайд****Жамсрангийн Баясах**

Доктор (Sc.D), профессор

Улаанбаатар, Монгол Улс

[bayasakhjk@gmail.com](mailto:bayasakhjk@gmail.com)

БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Монгол Улсыг судлах төвийн судлаач Боржигин Хөгжилт “Монгол Улсын эрдэс баялгийн хөгжлийн боломж нөөцөд хийсэн судалгаа ба Монгол, Хятадын хамтын ажиллагааны хэлбэр загварын тухайд” (蒙古国矿产资源开发潜力及中蒙合作形式研究) хэмээх нэгэн сэдэвт бүтээл туурвисан нь 2018 онд Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн газарт хэвлэгджээ. Энэхүү номын зохиогч Хөгжилт бол эрдэм судлалын эрхэм барилдлагатай эртний найз минь бөгөөд олон жилийн турш орчин үеийн Монгол Улс судлалаар дагнан ажилласан нэг ёсондоо “Монголыг сайн мэддэг” монголоор мэргэшсэн эрдэмтэн хүн юм.

Тэрбээр 1995 оноос Өвөр Монголын их сургуулийн Монгол Улсыг судлах төвд тасралтгүй ажиллахдаа БНХАУ-д хэрэгжсэн Монгол судлал ба Монгол Улс

судлалын чиглэлээрх томоохон төслүүдэд эдийн засгийн судалгаагаар дагнан оролцсоор иржээ. Мөн ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн болон МУИС-ийн Эдийн засгийн сургуульд мэргэжил дээшлүүлж, олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор манай улсад олонтоо зочилж, “Олон улс судлал”, “Олон улсын харилцаа”, “Пакс Монголика” зэрэг эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд олон өгүүлэл хэвлүүлсэн манай улсын эрдэм шинжилгээний хүрээнийхэнд танигдсан судлаач билээ.

“Цаг сайхан байхад” эрдмийн ерөөл буянаар үе үехэн уулзалддаг байсан бид хамгийн сүүлд 2019 оны зун Хөх хотод зохиогдсон олон улсын эрдэм шинжилгээний хурлын үеэр нүүр тулан уулзахад тэрбээр өлгийдөж аваад удаагүй байсан энэхүү бүтээлээ надад дурсгаж билээ. Удалгүй, цар тахалын хөл хорионд багагүй хугацаанд

Received: 25 October, 2022; Accepted: 26 October, 2022

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

гэртээн хашигдан суух болохуйд урьд завгүй шалтгаанаар хойш тавьж үзэж амжаагүй байсан номуудтай танилцах цаг гаруут бүхнээс өмнө Хөгжилтийнхөө энэхүү бүтээлийг барьж, шимтэн уншиж дуусгаж билээ. Найдвартай эх сурвалжаас ашигласан тоо баримтууд, хангалттай эмпирик дүн шинжилгээнд тулгуурласан уг бүтээлд хоёр орны язгуур ашиг сонирхолд нийцэх шинэ шинэлэг санаа, оновчтой дүгнэлтүүд ихээр агуулагдаж байна. Тэр тусмаа хоёр улсын эдийн засгийн харилцааны гол салбар болох эрдэс баялгийн хамтын ажиллагаанд харилцан ашигтайгаар хэрэгжүүлж болохуйц бодлогын саналуудыг дэвшүүлсэн нь тун чиг олзуурхууштай бас сайшаалтай байлаа. Тиймийн учир, уг бүтээлийг уншаад ганц биеэр өөртөө эрдмийн “олз” олоод өнгөрөх бус, харин Монголынхоо өргөн олон түмэнд танилцуулах шаардлагатай хэмээн сэтгэсэн тул энэхүү шүүмжийг чармайн бичиглэсний шалтгаан учир тэр болно.

Манай улс БНХАУ, ОХУ хэмээх хоёр аварга гүрний дунд хавчуулагдан оршдог газарзүйн өвөрмөц байрлалтай тул хөгжил дэвшлийн аливаа асуудал маань хоёр хөршөөс ихэд хамаардаг билээ. Тэр дундаа нэн хүчирхэг эдийн засагтай эрчимтэй хөгжиж буй БНХАУ-тай хэрхэн хамтран ажиллахаас ихээхэн шалтгаалах болоод удав. Өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур салбар бол яахын аргагүй уул уурхай, эрдэс баялгийн салбар мөн. БНХАУ-тай харилцах харилцаа, хэрэгжүүлэх хамтын ажиллагаанд ч энэхүү салбар тэргүүлэх байр суурьтай байхаас аргагүй. Мөн манай улсын гадаад худалдаанаас олох гол ашиг Хятадтай хамтарч буй энэ салбарын орлогоос

цөмлөн бүрдэж байдаг. Үүнтэй зэрэгцэн Монгол, Хятадын бие эзлэхүүний асар их зөрүүтэй байдлаас улбаалан монголчууд бид Хятадтай хамтрахдаа үндсэний аюулгүй байдалдаа ихээр эмзэглэдэг нь бодитой зүйл мөн. Иймээс хэрхэх нь зүйтэй вэ? Монголын талын энэ мэт бодит нөхцөл байдлыг сайтар харгалзсаны улмаас зохиогч хоёр улсын хамтын ажиллагааны хэтийн төлөвт сонирхолтой саналуудыг дэвшүүлжээ. Хоёр улс эрдэс баялгийн буюу гол салбарынхаа хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх нь зайлшгүй чухал бөгөөд чингэхийн зэрэгцээ нийтлэг ашиг сонирхолоо улам бүр өргөтгөж, улс төр, соёл хүмүүнлэг зэрэг бусад салбарын хамтын ажиллагаагаа ахиулах нь харилцан итгэлцлийг бэхжүүлэхэд маш чухал гэдгийг онцлов. Харилцан итгэлцэл буй бөгөөс харилцан ойлголцол төрж, хамтын ажиллагаа салбар бүрт өрнөх ба энэ бүхэн найрсаг харилцааг бэхжүүлэх зайлшгүй зам шугам гэдгийг дурдсан байна. Иймд, юу юуны өмнө талууд нийтлэг ойлголцолд хүрэхийг эрхэмлэж, эрдэс баялаг эрчим хүчний хамтын ажиллагааг ахиулах нь шинэ хэлбэрийн Монгол, Хятадын харилцааг үүтгэн байгуулахад нэн яаралтай шийдвэрлэх асуудал бөгөөд Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтын нэн тэргүүний зорилтын хэрэгжилтийг хангаж чадахыг бүлэг тус бүрдээ тохируулан дурдсан нь ихэд сонирхолтойгоор бичигджээ.

Энэхүү бүтээл оршил, 10 бүлэг, ном зүйгээс бүрдсэн, нийт 300 мянга илүү ханзтай 227 хуудас бүхий томоохон хэмжээний нэгэн сэдэвт зохиол юм. Эрдэмтэн Хөгжилтийн

холбогдох сэдвээр бичсэн сүүлийн үеийн судалгааны бүтээлүүд хийгээд БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны үндэсний сангийн судалгааны төслийн хүрээнд түүний гүйцэтгэсэн судалгааны үр дүнгийн нийлбэр болох юм.

Монгол, Хятадын харилцааны хөгжлийн үе шаг хэмээх тэргүүн хэсэгт, Монгол, Хятадын харилцааны хөгжлийн үе шатыг тоймлон авч үзэж, хоёр улсын харилцааны өнөөгийн байдлыг улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн хараанаас задлан шинжилжээ. Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн онцлого хэмээх хоёрдугаар хэсэгт, Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн хэд хэдэн онцлогийг хөрш зэргэлдээ улс орнууд, бүс нутаг хийгээд олон улсын үүднээс тодорхойлохыг оролдсон байна. Монгол, Хятадын ашигт малтмалын хамтын ажиллагааны харьцангуй давуу талууд хэмээх гуравдугаар хэсэгт, Монгол, Хятадын уул уурхайн хамтын ажиллагааны давуу талуудыг бодлогын уялдаа, газарзүйн ойр байршил, эдийн засгийн харилцан нөхсөн байдал, хүмүүнлэгийн зуучлалын хувьд нэгтгэн дүгнэжээ. Монгол, Хятадын ашигт малтмалын хамтын ажиллагааны геополитик, гео-эдийн засгийн ач холбогдол хэмээх дөрөвдүгээр хэсэгт, гео-стратегийн үүднээс Монгол, Хятадын эрдэс баялгийн хамтын ажиллагаа нь тус хоёр улсын хөршийн харилцаа, Зүүн Хойд Азийн эрдэс баялаг эрчим хүчний нийлүүлэлтийн бааз, Хятад-Орос, Хятад-Европыг холбосон дамжин өнгөрөх тээврийн зангилаа, бүс нутгийн интеграцлалыг бий болгоход гүйцэтгэх чухал үүрэгтэйг

тодорхойлжээ. Монгол Улсын ашигт малтмалын хөгжлийн нөөц чадавхи хэмээх тавдугаар хэсэгт, Монгол Улсын ашигт малтмалын төрөл, нөөц, байр суурь, тархалт, стратегийн ач холбогдол бүхий ордуудын талаар дэлгэрэнгүй танилцуулсан байна. Монгол Улсын уул уурхайн хөгжлийн өнөөгийн байдал хэмээх зургаадугаар хэсэгт, манай улсын өнөөгийн эдийн засаг, аж үйлдвэр дэх уул уурхайн салбарын эзлэх байр суурь, тус салбарын үйдвэрлэлийн гол хөдөлгөгч хүчин зүйл, хөрөнгө оруулалт, хайгуул, ашиглалтын лицензийн өөрчлөлт, үйлдвэрлэл, экспортийн хэмжээ зэрэгт дүн шинжилгээ хийжээ. Монгол, Хятадын ашигт малтмалын хамтын ажиллагааны онцлог хэмээх долдугаар хэсэгт, Монгол, Хятадын ашигт малтмалын хамтын ажиллагааг худалдаа, хөрөнгө оруулалт хэмээн хоёр хуваан авч үзэж, хоёр орны ашигт малтмалын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, онцлогийг статистик тоо баримт, тодорхой жишээнд тулгуурлан шинжилсэн байна.

Түүнчлэн Монгол, Хятадын ашигт малтмалын хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд хэмээх наймдугаар хэсэгт, засгийн газар болон аж ахуйн нэгжийн түвшинд, хоёр улсын уул уурхайн хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудал, бэрхшээлүүдийг тус тусад нь задлан шинжилж, улмаар нэгтгэн дүгнэжээ. Монгол, Хятадын ашигт малтмалын хамтын ажиллагаанд дэвшүүлсэн бодлогын зөвлөмж хэмээх есдүгээр хэсгийг мөн л засгийн газар болон аж ахуйн нэгж гэх хоёр түвшинд хуваан авч үзжээ. Чингэхдээ засгийн газрын түвшинд, Монгол Улсын нөөц баялаг хийгээд дамжин

өнгөрөх тээврийн ач холбогдлыг чухалчлах, төрийн чиг үүргийг оновчтой болгох, эрчим хүчний дипломат харилцааг эрчимжүүлэх, урт хугацааны хөгжлийн механизмыг буй болгох, гол төслүүдийг удирдан чиглүүлэх, харилцан холболтын дэд бүтэц, механизмыг бүтээн байгуулах, мэдээллийн хангамж болон салбарын удирдалгыг сайжруулах, Монгол, Хятадын чөлөөт худалдааны хэлэлцээрийн ТЭЗҮ-ийн судалгааг түргэсгэх гэх мэт тодорхой саналуудыг дэвшүүлжээ. Харин аж ахуйн нэгжийн түвшинд хөрөнгө оруулалтын урьдчилсан ТЭЗҮ-ийн судалгааг чухалчлах, Монгол Улсын үндэсний нөхцөл байдал, бодлого зохицуулалтын чиг хандлагатай нарийн танилцах, хөрөнгө оруулалтын ба санхүүжилтийн хэлбэрийг оновчтой сонгох, нийгмийн хариуцлагыг бэхжүүлэх, нутагшуулсан менежментийг хэрэгжүүлэх гэх мэтийг санал болгосон байна. Монгол, Хятадын ашигт малтмалын хамтын ажиллагааны хэтийн төлөв хэмээх төгсгөлийн аравдугаар хэсэгт, “Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор” байгуулах улс төрийн дээд түвшний тохиролцооноос Монгол, Хятадын ашигт малтмалын салбарын хамтын ажиллагаанд нэмэрлэсэн шинэ утга агуулгыг хайн шинжилж, хоёр талын хамтын ажиллагааны төлөв байдалтай уялдуулан, томоохон төсөл хөтөлбөрүүд тухайлбал, нүүрсийг хийжүүлэх ба шингэрүүлэх, нүүрс хими, нүүрсний эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, хэт өндөр цахилгаан шугам, газар доогуурх дамжуулах хоолой, дэд бүтэц болон боомтын бүтээн байгуулалт, усны нөөцийн хуваарилалт зэрэг хамтран ажиллах ирээдүйн хэтийн төлвийг зураглажээ.

Энэхүү бүтээлд геополитик, гео-эдийн засаг, олон улсын харилцаа, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны үүднээс хөрш орнууд бол БНХАУ-ын “Бүс ба зам” санаачилгыг хэрэгжүүлэх, хөгжлийн орон зайгаа өргөтгөх, энх тайвнаар зэрэгцэн хөгжих, Хятадын үндэстний агуу их сэргэн мандалтыг биелүүлэх стратегийн тулгуур бүс мөн гэж үзээд тус улсын дэвшүүлж буй “Бүс ба зам” санаачилга нь шугамын дагуух улс орнууд тэр дундаа Монгол Улсад хөгжлийн таатай нөхцөлийг олгож байгааг онцолжээ. Мөн бүхэлдээ онол, үзэл баримтлал, чиг хандлагын үүднээс БНХАУ-ын сэргэн мандлаас даян дэлхийн дэг журмын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөг авч үзэхийн зэрэгцээ тус улсын аюулгүй байдлын, хөршүүдтэйгээ сайн сайхны төлөөх хамтын нийгэмлэг байгуулах, хөршийн харилцаан дахь шинэ үзэл баримтлал, ёс ба ашгийг зохистойгоор хослуулах үзэл, эдийн засгийн шинэ хэвийн нөхцөл байдал дахь гадаад хамтын ажиллагааны агуулгыг Монгол Улсын геополитик, эдийн засгийн ашиг сонирхолын гол зорилтуудтай уялдуулан авч үзсэн байна. Чингэхдээ тогтвортой, хариуцлагатай, хүртээмжтэй, багтаамжтай “Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор”-ын хүрэн дэх уул уурхай хамтын ажиллагааны шинэ хэлбэр загвар байгуулах, улмаар аюулгүй, шуурхай, найдвартай Евразийг холбосон “Транзит Монгол” зорилтыг чухалчилж, Зүүн хойд Азийн эдийн засгийн интеграцчиллыг ахиулах, Монгол, Хятадын шинэ хэлбэрийн харилцааг үүтгэн бэхжүүлэхэд ажил хэрэгч, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогын саналуудыг дэвшүүлсэн байна.

БНХАУ нь Монголын хамгийн том худалдааны түнш, хөрөнгө оруулалтын хоёр дахь эх үүсвэр бөгөөд эдгээр нь уул уурхай эрчим хүчний салбарт төвлөрдөг. Хэрэв Монгол, Хятад хоёр газарзүйн ойр дөхөм, эдийн засгийн харилцан нөхсөн, соёл хүмүүнлэгийн улам бүр сайжирч байгаа харилцаа зэрэг давуу талаа сайтар ашиглаж, “баялагийн хараал” зэрэг бэрхшээл сорилтыг хамтдаа гэтэлж, хөгжлийн амин чухал ашиг сонирхлоо харгалзан, тус салбарын өндөр чанартай хамтын ажиллагааг эрчимтэй өрнүүлж чадваас эдгээр нь юуны өмнө Монголын эдийн засгийг төрөлжүүлэн шинэчлэхэд нөгөөтэйгүүр Хятадын эрчим хүчний нийлүүлэлтийн аюулгүй байдлыг хангахад онол, практикийн чухал ач холбогдолтой байж болохыг уг бүтээлд онцолж байна.

Хэдийгээр энэхүү нэгэн сэдэвт зохиол коронавируст цар тахал дэгдэхээс өмнөх байдалд тулгуурлан бичигдсэн ч бүхэлдээ Монгол Хятадын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд орхигдуулж үл болох судалгааны чухал хэрэглэгдэхүүн болж чадсан

нь тун сайшаалтай. Өдгөө манай засгийн газраас дэвшүүлээд буй хөгжлийн урт, дунд хугацааны хөтөлбөрүүд болох “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд, улмаар Монгол, Хятад хоёр улсын хөгжлийн бодлогын уялдаа холбоог хангахад хэрэглэж болохуйц олон чухал ул суурьтай санаа гаргалгааг нэмэрлэж байна. Ялангуяа БНХАУ-ын зүгээс дэвшүүлээд буй “Бүс ба зам”, “Хүн төрөлхтний хувь заяаны хамтын нийгэмлэг” санаачилгууд хийгээд тус улсаас баримталж буй хөрш орнуудын талаарх бодлогыг сэдвийн хүрээнд хамаатуулан нарийвчлан өгүүлсэн нь хөрш монголчууд бидний хувьд олзуурхууштай тун чухал болжээ. Энэ бүхэн нь манай улсын эрдэм шинжилгээнийхэн хийгээд өргөн олон уншигчдын хүсэл шаардлагад нийцэхүйц даацтай бүтээл болсон гэдгийг илтгэж байгаа юм.

*2022 оны 10 дугаар сар*